

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-6</i>
<hr/>	
<i>1. Монгол Улсын Ерөнхий аудиторыг албан тушаалаас нь чөлөөлөх тухай санал</i>	<i>4-5</i>
<i>2. “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	<i>5-6</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 12 дугаар сарын 28-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 06 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Чөлөөтэй: Г.Амартүвшин, Л.Мөнхбаатар, Ц.Сандаг-Очир, Ч.Хүрэлбаатар;
Томилолттой: Ц.Анандбазар, Д.Өнөрболор.*

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн хэлэлцэх асуудлын дарааллын 4 дүгээрт байгаа “Монгол Улсын Ерөнхий аудиторыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын 1 дүгээрт хэлэлцэх, мөн 2, 3 дугаарт байгаа Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан болон 2023-2025 оны стратегийн хэрэгжилтийн тайлан сонсох асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллаас хасах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан болон 2023-2025 оны стратегийн хэрэгжилтийн тайлан сонсох асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллаас хасахаар тогтов.

Нэг.Монгол Улсын Ерөнхий аудиторыг албан тушаалаас нь чөлөөлөх тухай санал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын саналыг танилцуулав.

Саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбатыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх нь зүйтэй гэсэн Улсын Их Хурлын даргын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 7
Бүгд: 12
41.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр батлах саналыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 10 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 10 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим, 10 цаг 06 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Булгантуяа гишүүн, Одонтуяа гишүүн, Баделхан гишүүн, Даваасүрэн гишүүн, Пүрэвдорж гишүүн, Батжаргал гишүүн, Жавхлан гишүүн, Раднаасэд гишүүн, Чойжилсүрэн гишүүн, Батсуурь гишүүд хүрэлцэн ирснээр, Ганбаатар гишүүн бас хүрэлцэн ирсэн байна. Ингээд ирц бүрдсэн тул өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1. “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

2. Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

3. Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан болон 2023-2025 оны стратегийн хэрэгжилтийн тайлан.

4. Бусад, Монгол улсын ерөнхий аудиторыг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл гэсэн ийм 4 асуудал байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу. Надад

горимын санал байна. Өнөөдрийн 4 асуудлаас бусад асуудлыг 1 дэх асуудал болгож, 1 дэх асуудлыг 2 дахь асуудал болгох, 2, 3 дахь асуудлыг бол дараагийн 7 хоногт хэлэлцэхээр хойшлуулах саналтай байна. Тэгээд горимын саналыг бас дэмжиж өгөөч гэсэн саналыг та бүхэнд гаргаж байна. Санал хураалт. Санал хураалтын дүнг танилцуулъя. 12 гишүүн санал хураалтад оролцсоноос 7 гишүүн дэмжиж, 58,3 хувиар дэмжигдлээ.

Ингээд 1 дэх асуудал буюу Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай,

2. “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд байгаа.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё.

1 дэх асуудал. Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбатыг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Ерөнхий аудитор Занданбат үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ Улсын Их Хурлын дарга Занданшатарт ирүүлсэн байна. Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай саналыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 46 дугаар тогтоолоор Доржсүрэн овогтой Занданбатыг Монгол Улсын Ерөнхий аудитораар томилсон бөгөөд Занданбат нь Монгол Улсын 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшихээ

илэрхийлж, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Төрийн аудитын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалтыг үндэслэн 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.15 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Доржсүрэн овогтой Занданбатыг Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай саналыг эрхлэх асуудлын харьяаллын дагуу Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороогоор хэлэлцүүлэхээр хүргүүлж байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай саналыг хэлэлцэж өгөхийг хүсье гэж Монгол Улсын Их Хурлын дарга Занданшатар дарга ирүүлсэн байна.

Ингээд санал болон хүсэлттэй холбогдуулж асуулт асуух, үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байгаа.

Тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулсан. Та бүхэнд тараасан байгаа. Ингээд тогтоолын төсөлтэй холбоотойгоор саналтай гишүүд байна уу. Алга байна. Санал хураалтыг явуулж эхэлье. Горимын санал. Батсуурь гишүүн горимын санал гаргах нь байна.

Ж.Батсуурь: Дахин санал хурааж өгөх үү. Миний э нөгөө хорооны хээ уншихгүй байх шиг байна.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. Батсуурь гишүүний гаргасан горимын саналаар дахин санал хураалтыг явуулъя. Хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал

хураалт. Өмнөх санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт. 58,3 хувиар дэмжигдлээ. Энэ санал хураалт дэмжигдсэн тул Монгол Улсын Ерөнхий аудиторыг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудлыг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 58,3 хувиар дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

10.12 цаг.

2 дахь асуудалдаа оръё. “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Төслийн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, миний бие танилцуулна. Та бүхэнд тогтоолын төслийг тараасан байгаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 1.1 дэх хэсэгт энэ хуулийн зорилт нь нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавихад төрийн байгууллагын бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, эрдэс баялгийн орлогоор нөхөн сэргээгдэх баялаг бүтээх, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн хуримтлал бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж заасан байгаа. Үүнтэй холбогдуулаад зөвлөлийн дарга, гишүүдийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16.1 дэх хэсэгт заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн бүтэц нь Улсын Их Хурлын тухай хуулийн 4.4-д зааснаар Улсын Их Хурал мэргэисэн чадварлаг ажлын

албатай байх бөгөөд байнгын үйл ажиллагаа явуулах техник, тоног төхөөрөмжөөр хангагдана гэж заасны дагуу Улсын Их Хурлын дэргэд үйл ажиллагаа явуулах ба төсвөөс санхүүжнэ. Ингээд Төсвийн тогтоолын тухай хуулийн 16^{1.9} зөвлөлийн дарга, гишүүдийн цалингийн хэмжээг Улсын Их Хурал батална гэж заасны дагуу тогтоолын төсөл боловсруулсныг та бүхэнд танилцуулж байна. Ингээд тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу. Үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт 58,3 хувиар дэмжигдлээ. Санал дэмжигдсэн тул анхны хэлэлцүүлгээр нь батлуулах горимын санал гаргаж байна. Анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн горимын саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 66,7 хувиар дэмжигдлээ.

Ингээд “Төсвийн тогтоолын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Пүрэвдорж гишүүн танилцуулна.

Ингээд тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

10.16 цаг.

Ерөнхий аудитортай холбоотойгоор I дүгээр асуудлыг сэргээгээд “Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” асуудлыг Байнгын хорооны гишүүд олонх нь дэмжсэн байгаа. Ингээд тогтоолын төслийг олонх нь дэмжсэн тул анхны хэлэлцүүлгээр нь хэлэлцье гэсэн горимын саналыг бас гаргаж байна. Баталъя гэсэн. Анхны хэлэлцүүлгээр нь хэлэлцэж баталъя гэсэн.

Уучлаарай бас техникийн алдаа гарсан байна. Юу юм байна шүү. Санал дүгнэлтийг унших гишүүнийг томилох ёстой юм байна. Би уншихъя даа. Ингээд чуулганы хуралдаанд Ерөнхий аудиторыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай тогтоолын төслийг миний бие танилцуулъя.

Ингээд хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

10.16 цаг

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ